



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН
ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГИЙН
АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ**





Өмнөговь аймагт 2016-2022 онд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ЯОУХАБ /ЖАЙКА, Бүгд Найрамдах Беларусь Улсын хөгжлийн банкны дамжуулан зээлдүүлэх төслүүдээс 5 зээл, 1 тусламж нийт 6 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна.

N	Эх үүсвэр	Он	Төслийн нэр	Зориулалт	Мөнгөн дүн /сая.төг/	Төрөл	Дууссан эсэх
1	БНБУ-н хөгжлийн банк	2022	Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх төсөл	Трактор, хөдөө аж ахуйн техник нийлүүлэх	59.1	Зээл	Тийм
2	Азийн хөгжлийн банк	2021	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	Өмнөговь аймгийн бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх	26.6	Зээл	Тийм
3	Азийн хөгжлийн банк	2021	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл	3,038.2	Зээл	Үгүй
4	Азийн хөгжлийн банк	2022	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн Нэмэлт санхүүжилт	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх зээл	3,300.0	Зээл	Үгүй
5	ЯОУХАБ /ЖАЙКА	2021	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай төсөл	Жижиг дунд бизнесийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх	510.0	Зээл	Үгүй
6	Дэлхийн банк	2021	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	Аймгийн өвөлжилт хүндэрсэн 10 сумын малчин өрхүүдэд 1,045,000 кг тэжээл нийлүүлэх	1,226.8	Тусламж	-



Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээ нь хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байна.



Хөдөө аж ахуйн салбарт олгосон зээлүүдийг зориулалтын дагуу ашиглаж, эргэн төлөлт хэвийн байна.


Беларусь-320.4 трактор тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл Хөдөө аж ахуйг дэмжих сангийн дансанд төлбөр болох 59.1 сая төгрөгийг шилжүүлэн гэрээний үүргээ 100 хувь биелүүлсэн байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслөөс мах, махан бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хаан хүнс ХХК Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан 3,038.2 сая төгрөгийн зээл авсан ба эргэн төлөлт хэвийн байна.

Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт төслөөс мах, махан бүтээгдэхүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Солид партнерс ХХК Худалдаа хөгжлийн банкаар дамжуулан 3,300.0 сая төгрөгийн зээл авсан ба эргэн төлөлт хэвийн байна.



Өмнөговь аймгийн өвөлжилт хүндэрсэн 10 сумын малчин өрхүүдэд “Тэжээл” аппликейшн ашиглан тэжээлийн олголт хийсэн байна.



МОНГОЛ
СЭМЖ
ХӨВӨЛЖИЛТ
ХҮНДЭРСЭН



Анхаарах асуудал



Трактор, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх” төслийн хүрээнд 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр Беларусь-320.4 трактор, ургамал хамгааллын бодис цацагч ЗУБР-НШ-600, сийрүүлэгч манагч КОН-1.4А-уудыг ашиглуулах гэрээг шинэчлэн байгуулах



Хөнгөлөлтэй үнээр үйлчлэх тарифыг зах зээлийн үнийг судлан шинэчлэн тогтоож байх



Үйлчилгээ үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэлжүүлж, хяналт тавих.